



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Гадаад сургалтад хамруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.37, 5.41, 5.42, 5.43 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тайландын Вант Улсын "АэроТай" компанид 2022 оны 4 дүгээр сарын 17-ноос 30-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Ойртолтын болон ойртолтын ажиглалтын нислэгийн удирдлагын зэрэглэл эзэмшигч нарын сэргээх, давтан сургалт (2-р ээлж)"-д Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Ойртолтын удирдлагын үйлчилгээний хэсгийн ээлжийн ахлах нислэгийн хөдөлгөөний удирдагч Г.Мөнхбадрах, Б.Түвшинтөр, Д.Батболд, Н.Мөнх-Эрдэнэ, ойртолтын ажиглалтын нислэгийн хөдөлгөөний удирдагч Д.Даваахүү, Б.Солонго, Э.Энх-Оюун, Г.Орхонтунгалаг нарыг тус тус хамруулсугай.

2. Гадаад сургалттай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ч.Нямсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3. Гадаад сургалтад хамрагдсан тухай тайланг ажлын 5 хоногийн дотор удирдлагад танилцуулахыг дээрх ажилтнуудад, ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (Г.Батбулган)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газар (Г.Батбаяр), Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (П.Мөнхжаргал)-д тус тус даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН